

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 24 ДЭХ ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН
ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.6 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцлээ.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудал, Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх санал, зөвлөмжийн танилцуулгыг Байнгын хорооны хуралдаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, Х.Мөнхзул нарын гишүүд танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл давтан үйлдсэн хүмүүсийн мэдээлэл байгаа эсэх, цахим орчин дахь гэмт хэрэг ихсэж байгаа тул хуурамч хаягуудыг цэгцэлж, албан ёсны бүртгэлтэй хаягаар ашиглахыг хэрэгжүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах мөрдөн байцаагч байдаг эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хүүхэд хүчирхийлсэн этгээдэд хилийн хориг тавьдаг эсэх, үр шилжүүлэн суулгах болон тээгч эхийн асуудалтай холбоотой хүүхдийн эрх зөрчигдэж байгаа талаарх судалгаа байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Хүний эрхийн Үндэсний Комиссын өмнөх илтгэлүүдийн зөвлөмжүүдийн биелэлтийн талаар, хүүхэд хамгааллын чиглэлд хууль, эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Булгантуяа цахим орчинд эмэгтэйчүүд илүү дарамт, хүчирхийлэлд өртдөг, энэ талаарх судалгаа, мэдээлэл байгаа эсэх, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагыг сулруулсанд Хүний эрхийн Үндэсний Комисс ямар байр суурьтай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ цахим орчны хэрэглээг хязгаарлах, хянахад тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд ямар ажил хийж байгаа талаар, эрэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Жендэрийн үндэсний хороо ямар бодлого баримталж байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Хүний эрхийн Үндэсний Комисс 25 дахь илтгэлдээ хүүхдийн амьд явах эрх хэрхэн хангагдаж байгаа судалгаа, дүгнэлт гаргах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн эрхийг цахим орчинд хамгаалах талаар тус тус саналаа илэрхийллээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцүүлж, Байнгын хорооны гишүүдээс гаргасан саналыг үндэслэн холбогдох тогтоолын төсөлд дараах саналыг тусгуулахаар санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж байна. Үүнд:

1. Цахим орчин дахь хуурамч хаягуудыг хааж, албан ёсны бүртгэлтэй хаягаар цахим орчинд нэвтрэх, ашиглах шаардлагыг судалж, хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
2. Хүний эрхийн Үндэсний Комисс, Жендерэйин үндэсний хорооноос гаргадаг санал, зөвлөмжийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Хууль зүй, дотоод хэргийн яам хамтарч цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч ажиллах;
3. Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн Ялгаварлан гадуурхах, 10.4 дүгээр зүйлийн Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 11.7 дүгээр зүйлийн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, 13.1 дүгээр зүйлийн Хүн худалдаалах, 13.5 дугаар зүйлийн Заналхийлэх, 13.12 дугаар зүйлийн Хууль бусаар мөрдөж, мөшгих зэрэг гэмт хэргүүдийн хүндруүлэх нөхцөл байдалд цахим орчныг ашиглан үйлдсэн шинжийг нарийвчлан тусгах;
4. Хүний эрхийн Үндэсний комисс 25 дахь илтгэлдээ хүүхдийн амьд явах эрх хангагдаж байгаа эсэх талаар, хөвгүүд, эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, тэдний эрхийг хангах чиглэлээр судалгаа, дүгнэлтийг хийж, танилцуулах;
5. Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн судалгааг нарийвчлан гаргаж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, криминологийн дэлгэрэнгүй судалгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудын төлөөллийг оролцуулан хийх, судалгааны үр дүнг үндэслэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх арга, хэлбэрийг шинэчлэх;
6. Бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орж таашаал авдаг гаж зан үйлийн эмгэгтэй гэмт хэрэгт холбогдогчид сэтгэцийн шинжилгээ хийх журмыг боловсруулах, энэ төрлийн эмгэгийг оношлох, эмчлэх, эмгэгтэй хүнд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
7. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалсан, дахин хохирохоос урьдчилан сэргийлсэн тусгай журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах;
8. Насанд хүрээгүй болон бага насны хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааг мэргэжлийн, бэлтгэгдсэн сэтгэл зүйч эсвэл нийгмийн ажилтнаар ярилцлага хийлгэх замаар дагнан, нэг удаа, чанартай, шуурхай явуулж, дуу, дүрсний бичлэгээр баримтжуулж нотлох баримтад тооцох хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

9. Хүүхдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг авахдаа хүүхдэд аюулгүй, ээлтэй, хүртээмжтэй орчинд хийх;
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхэд заавал өмгөөлөгчтэй оролцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
11. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд учирсан хохирлыг заавал тодорхойлж, тогтоох, тэр дундаа нөхөн сэргээх, сэтгэл заслын зардлыг хэргийн хамт шийдвэрлэдэг болох, үүссэн хохирлыг эхний ээлжид төрөөс нөхөн барагдуулж, төр гэм буруутай этгээдээс дараа нь нэхэмжлэн гаргуулдаг байх зохицуулалтыг хийх;
12. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын тогтолцооны хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын оролцоог нэмэгдүүлэх;
13. Насанд хүрээгүй хүний эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт гагцхүү мэргэшсэн, тусгайлан бэлтгэгдсэн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, мөрдөгч, прокурор, шүүгчийг оролцуулах.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 24 дэх илтгэлийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**  **Л.ЭНХНАСАН**

TU03761 9020051294 9067184